



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар зарим алдаа, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 94.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (В.Адьяад) дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан үр ашигтай байх зарчмын хүрээнд сургалтын болон бүтээмжийн хэлтсүүдийг нэгтгэж, бүтэц орон тоог хэмнэн ажиллах;

2.3.Компанид мөрдөж байгаа дүрэм, зарим журам, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж, журмын давхардлыг арилгах, шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах;

2.4.Төслийн хүрээнд бий болсон зээлийн эргэн төлөлтийн хугацаанд анхаарч өр зээлийн дарамт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн эргэн төлөлтөд шаардагдах мөнгөн хөрөнгийн нөөцийг бүрдүүлэх;

2.5.Компанийн үндсэн үйл ажиллагаанд шууд хамааралгүй, ашиглалтын шаардлага хангахгүй, ашиглалтгүй 20 ширхэг, 156.3 сая төгрөгийн үлдэгдэл үнэ бүхий орон сууны барилга, Бөхөнгийн зуслангийн 10 ширхэг, 124.7 (нэг зуун хорин дөрвөн сая долоон зуун мянга) сая төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн зуны байрыг худалдах, хувьчлах, шилжүүлэх асуудлаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

2.6.Ашиглалтын хугацаа дууссан болон дуусаагүй, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын модон тулгууруудыг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар Эрчим хүчний яам болон холбогдох

132005719
18-r_huraldaan.docx

байгууллагуудад санал боловсруулан хүргүүлэх;

2.7.Компанийн авто зогсоолын болон салбаруудад хамаарах бүртгэлгүй газруудын судалгааг гаргаж газар эзэмших эрхийг баталгаажуулах, үнэлж санхүүгийн тайланд тусгах, бүртгэх;

2.8.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, бусдын эзэмшил газар дээр байрладаг КТП, ХТП, АТП-ын барилга, байгууламжуудад хамаарах эзэмшил газрыг компанийн нэр дээр шилжүүлэн баталгаажуулах ажлыг зохион байгуулах.

3.Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА